



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/08.

Улаанбаатар хот

### Нийслэлийн Өмчийн харилцааны газрын балансад эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 82 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/84 дүгээр захирамжыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сувилал, сургалт, эрдэм шинэжилгээ, судалгаа төв”-ийн 40,860,300.00 (дөчин сая найман зуун жаран мянга гурван зуу) төгрөгийн үнэ бүхий барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1425010110



ॐ नमो भगवते वासुदेवाय  
ॐ नमो भगवते वासुदेवाय



ॐ नमो भगवते वासुदेवाय

ॐ नमो भगवते वासुदेवाय

ॐ नमो भगवते वासुदेवाय